



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар A/637

Номгон

«Шүүхийн шинжилгээний албанд нийлүүлэх  
суудлын машин хүлээж авах ажлын хэсэг  
томилох тухай»

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2."а, г" заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албанд нийлүүлэх суудлын автомашиныг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Сарангарав – Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд: Г.Баатартогтох- Орон нутгийн өмчийн газрын Өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Ганцэцэг- Шүүхийн шинжилгээний албаны дарга

Ч.Батбилэг - Шүүхийн шинжилгээний албаны нягтлан бодогч

А.Баярболд-Шүүхийн шинжилгээний албаны ахлах шинжээч


Г.Базардарь - Шүүхийн шинжилгээний албаны жолооч

Нарийн бичгийн дарга: Д.Отгонтөгс - Кодификаторч

2. Тээврийн хэрэгслийг 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүлээн авч байгууллагын өмчид бүртгэж авахыг (Б.Ганцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албанд нийлүүлэх суудлын автомашиныг техникийн тодорхойлолттой тулган хүлээн авч ажлын тайланг 10 дугаар сарын 30-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д даалгасугай.



601210533

D:\2021\Zakhiramj-2021 он\Захирамж-2021 он+.docx